



НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,
Баримт нягтлан шалгах комиссын
ажиллах журам, бүрэлдэхүүн
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12 дахь хэсэг, Хөдөлмөрийн “дотоод журам”-ын 2.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Баримтын нягтлан шалгах комиссын ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Г.Ганхүү)-т даалгасугай. 3.Тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2023 оны 10 дугаар 11-ний өдрийн А/84 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.ГОВЬСАЙХАН

1725010342

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 08 дугаар сарын 03-ны
өдрийн 100 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

100



**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9.1-д зааснаар газрын дэргэд архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, хадгалах хугацааг тодорхойлох, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Баримт нягтлан шалгах комисс (цаашид “БНШК” гэх) ажиллана.

1.2.БНШК-ын бүрэлдэхүүнийг газрын даргын тушаалаар батална.

1.3.БНШК нь орон тооны бус 3-11 хүний бүрэлдэхүүнтэй байна.

1.4.БНШК нь үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаал “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг удирдлага болгоно.

Хоёр. БНШК-ын чиг үүрэг

2.1.БНШК нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.БНШК нь жилд нэгээс доошгүй удаа 70-аас дээш хувийн ирцтэйгээр хуралдаж, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. БНШК-ын хурлыг уг хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

2.3.Газрын архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах,

2.4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6.1.11-д заасан жагсаалтыг үндэслэн газрын баримт бичгийн хадгалах хугацааг, тодорхойлох,

2.5.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх,

2.6.Хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөр, үнэлгээний хороо, ажлын хэсгийн холбогдох баримт бичгүүдийн бүрдэлд Архивын эрхлэгчтэй хамтран хяналт тавих,

2.7.Архивт хүлээн авсан байнга болон түр хадгалах, 70 жил хадгалах, тусгай төрлийн баримтын данс бүртгэл, устгах баримтын жагсаалтыг хянан хэлэлцэх,

2.8.Хэлтэс болон албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн шатны баримт бичгийн хөтлөлт, бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын байдалд жилд 1-ээс доошгүй удаа үзлэг шалгалт хийх,

2.9.Төрийн архивт шилжүүлэх баримтыг сонгож,

2.10.Архивын баримтын хадгалалт, ашиглалтын байдалд хохирол учруулах онцгой нөхцөл үүсгэж болзошгүй буюу үүссэн тохиолдолд холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

2.11.Баримт нягтлан шалгах комисс архивын баримттай холбогдох маргаантай асуудлаар харьяалах төрийн архивын баримт нягтлан шалгах арга зүйн комисст хандаж мэргэжил, арга зүйн туслалцаа авна.

----oOo----

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 08 дугаар сарын 25-ны
өдрийн 9/100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



БАРИМТ НЯГТЛАН
ШАЛГАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Г.Ганхүү	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн дарга;
Гишүүд:	Х.Долгорсүрэн	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Хууль, дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын инженер;
	Г.Ариунцэцэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер;
	О.Шүрэнцэцэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн;
	Ө.Эрдэнэчимэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч;
	О.Мөнгөнтуяа	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн;
	Д.Оюунбилэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Системийн мэргэжилтэн;
	Б.Хишигмаа	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Бичиг хэргийн эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;